

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Навч яагаад унадаг вэ?

Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг ногоон өнгөтэй болгодог мөхлөг нь задардаг. Навчны эсийн дотор улаан шар өнгөтэй будагч бодис үлдсэнээс навч улайх, шарлах зэргээр хувирна. Хүйтрэхэд ургамал хөрснөөс ус авах нь багасна. Түүнчлэн навч хөгширдөг. Энэ үед навчны эсэд ургамлын амьдралд хэрэггүй эрдэс давс их хэмжээгээр хуримтлагдсанаас навч унадаг.

Ямагт навчтайгаа байдаг ургамлыг мөнх ногоон ургамал гэнэ. (Д.Базаррагчаа)

1. Эхийн гол санааг бичээрэй.
2. "навчсыг" гэдэг үгийг бүтцээр задлаад, ижил бүтэцтэй үг нэгийг бичнэ үү?
3. "Салхи хэсэг зуур намжлаа." Өгүүлбэрийн гол гишүүдийг зурж, цөм өгүүлбэрийг ялган тодорхойлоорой.
4. "Түүнчлэн навч хөгширдөг" өгүүлбэрийн түүнчлэн гэх үгийг ямар үгээр солин найруулж болох вэ?
5. "Хүйтрэхэд" гэсэн үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаарай.
6. "Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг ногоон өнгөтэй болгодог **мөхлөг** нь задардаг" тодруулсан үг ямар тийн ялгалд байна вэ?
7. Эхээс эс тусах үйл үг 3-ыг олж бичнэ үү.
8. "Ямагт **навчтайгаа** байдаг ургамлыг мөнх ногоон ургамал гэнэ" тодруулсан үг ямар үгсийн аймгийн үг вэ?
9. "Хошуу нэмэх" хэлцийн утгыг тайлбарлаарай.
10. Алдаатай үгсийг олоод, засаж бичээрэй.
Голын ус өвөл хөлднө. Ус хөлдбөл мөс болно. Мөс хайлхаараа ус болно. Усны уур дээш тэнгэрт хөөрөнө. Тэгээд бороо цас болон доош бууна.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Навч яагаад унадаг вэ?

Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг ногоон өнгөтэй болгодог мөхлөг нь задардаг. Навчны эсийн дотор улаан шар өнгөтэй будагч бодис үлдсэнээс навч улайх, шарлах зэргээр хувирна. Хүйтрэхэд ургамал хөрснөөс ус авах нь багасна. Түүнчлэн навч хөгширдөг. Энэ үед навчны эсэд ургамлын амьдралд хэрэггүй эрдэс давс их хэмжээгээр хуримтлагдсанаас навч унадаг.

Ямагт навчтайгаа байдаг ургамлыг мөнх ногоон ургамал гэнэ. (Д.Базаррагчаа)

1. Эхийн гол санааг бичээрэй.
2. "навчсыг" гэдэг үгийг бүтцээр задлаад, ижил бүтэцтэй үг нэгийг бичнэ үү?
3. "Салхи хэсэг зуур намжлаа." Өгүүлбэрийн гол гишүүдийг зурж, цөм өгүүлбэрийг ялган тодорхойлоорой.
4. "Түүнчлэн навч хөгширдөг" өгүүлбэрийн түүнчлэн гэх үгийг ямар үгээр солин найруулж болох вэ?
5. "Хүйтрэхэд" гэсэн үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаарай.
6. "Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг ногоон өнгөтэй болгодог **мөхлөг** нь задардаг" тодруулсан үг ямар тийн ялгалд байна вэ?
7. Эхээс эс тусах үйл үг 3-ыг олж бичнэ үү.
8. "Ямагт **навчтайгаа** байдаг ургамлыг мөнх ногоон ургамал гэнэ" тодруулсан үг ямар үгсийн аймгийн үг вэ?
9. "Хошуу нэмэх" хэлцийн утгыг тайлбарлаарай.
10. Алдаатай үгсийг олоод, засаж бичээрэй.
Голын ус өвөл хөлднө. Ус хөлдбөл мөс болно. Мөс хайлхаараа ус болно. Усны уур дээш тэнгэрт хөөрөнө. Тэгээд бороо цас болон доош бууна.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Хүнд хоол

Нэг гүрний хаан ан гөрөө хийж яваад төөрч хэд хоног хоол ундгүй явж байгаад нэгэн овоохойд очжээ. Овоохойд ганц бие эмгэн байж гэнэ. Тэр эмгэн усанд шар будаа чанаж өгчээ. Тэр нь хаанд хүн болсоор идэж үзээгүй амттай хоол байжээ. Хаан ордондоо буцаж ирээд шар будаагаар янз бүрийн хоол хийлгэж идсэн боловч эмгэний хийж өгсөн хоол шиг амттай болохгүй байв. Хаан уурлаж: - Та нар тэр эмгэн шиг сайхан хоол хийж чадахгүй байна. Тэр эмгэнийг олж ир гэжээ. Эмгэн ирээд: - Миний хоол бол хүнд хоол юм. Ийм учраас хаантан минь та гурав хоног зоог барихгүй бай гэжээ. Хаан сайхан хоол идэх гэж гурав хоног хүлээжээ. Эмгэн усанд чанасан шар будаа өгөхөд хаан: - Яг ийм амттай сайхан хоол байсан юм гээд иджээ.

1. "Хүнд хоол" гэдэг үгийн утгыг тайлбарлаарай.
 2. Эхийн гол санааг илэрхийлэх хэлцийг олоорой.
А. Цадахад цагаан хурганы сүүл хатуу
Өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн
 - Б. Нуухыг нь авах гээд
Нүдийг нь сохлох
 - В. Нэг чихээрээ оруулаад
Нөгөө чихээрээ гаргах
 3. Эхийн хэв маягийг тодорхойлоорой.
 4. "Тэр эмгэн усанд **шар будаа** чанаж өгчээ" тодруулсан үг ямар тийн ялгалд байна вэ?
 5. "Та нар тэр эмгэн шиг сайхан хоол хийж чадахгүй байна" гэх өгүүлбэрт ямар уран дүрслэл байна вэ?
 6. "Овоохойд ганц бие эмгэн байж гэнэ" өгүүлбэрийн цөм бүтцийг олоорой.
 7. Эхээс тодотгон холбох нөхцөлтэй үг 3-ыг олж бичнэ үү.
 8. "Дотор газраас өр нэхэх" хэлцийн утгыг тайлбарлаарай.
 9. "Хоол" гэх үгийг нэрийн тийн ялгалаар хувилгаарай.
 10. Алдаатай үгсийг олоод, засаж бичээрэй.
- Зөв бичихийн ийм чадварыг эзэмшхэд үсгийн болон цэг цэглэлийн дүрмийн бүх тохиолдолыг түргэнээр санаж, тухайн үгэнд аль нь холбогдож байгааг мэдэхийн чухалыг туршлагаар батласан байна. Багс авснаар нь саравч будуулаж, хүрз бариснаар нь газрын хөрс харуулж, үтрэм байгуулав.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Хүнд хоол

Нэг гүрний хаан ан гөрөө хийж яваад төөрч хэд хоног хоол ундгүй явж байгаад нэгэн овоохойд очжээ. Овоохойд ганц бие эмгэн байж гэнэ. Тэр эмгэн усанд шар будаа чанаж өгчээ. Тэр нь хаанд хүн болсоор идэж үзээгүй амттай хоол байжээ. Хаан ордондоо буцаж ирээд шар будаагаар янз бүрийн хоол хийлгэж идсэн боловч эмгэний хийж өгсөн хоол шиг амттай болохгүй байв. Хаан уурлаж: - Та нар тэр эмгэн шиг сайхан хоол хийж чадахгүй байна. Тэр эмгэнийг олж ир гэжээ. Эмгэн ирээд: - Миний хоол бол хүнд хоол юм. Ийм учраас хаантан минь та гурав хоног зоог барихгүй бай гэжээ. Хаан сайхан хоол идэх гэж гурав хоног хүлээжээ. Эмгэн усанд чанасан шар будаа өгөхөд хаан: - Яг ийм амттай сайхан хоол байсан юм гээд иджээ.

1. "Хүнд хоол" гэдэг үгийн утгыг тайлбарлаарай.
 2. Эхийн гол санааг илэрхийлэх хэлцийг олоорой.
А. Цадахад цагаан хурганы сүүл хатуу
Өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн
 - Б. Нуухыг нь авах гээд
Нүдийг нь сохлох
 - В. Нэг чихээрээ оруулаад
Нөгөө чихээрээ гаргах
 3. Эхийн хэв маягийг тодорхойлоорой.
 4. "Тэр эмгэн усанд **шар будаа** чанаж өгчээ" тодруулсан үг ямар тийн ялгалд байна вэ?
 5. "Та нар тэр эмгэн шиг сайхан хоол хийж чадахгүй байна" гэх өгүүлбэрт ямар уран дүрслэл байна вэ?
 6. "Овоохойд ганц бие эмгэн байж гэнэ" өгүүлбэрийн цөм бүтцийг олоорой.
 7. Эхээс тодотгон холбох нөхцөлтэй үг 3-ыг олж бичнэ үү.
 8. "Дотор газраас өр нэхэх" хэлцийн утгыг тайлбарлаарай.
 9. "Хоол" гэх үгийг нэрийн тийн ялгалаар хувилгаарай.
 10. Алдаатай үгсийг олоод, засаж бичээрэй.
- Зөв бичихийн ийм чадварыг эзэмшхэд үсгийн болон цэг цэглэлийн дүрмийн бүх тохиолдолыг түргэнээр санаж, тухайн үгэнд аль нь холбогдож байгааг мэдэхийн чухалыг туршлагаар батласан байна. Багс авснаар нь саравч будуулаж, хүрз бариснаар нь газрын хөрс харуулж, үтрэм байгуулав.

Эхнийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

"Эрсдэл"

Буудайн хоёр үр тариан талбай дээр унажээ. Эхний үр хэлсэн нь "Би ургахыг хүсэж байна. Би өөрийн үндсээ хөрсөнд ургуулж, соёогоо газрын гадарга дээр гарган, нарны гэрлийг харж, навчин дээрээ шүүдрийн дусал буугаасай гэж хүсэж байна." гэлээ. Удалгүй тэр хүссэнээрээ сайхан ургажээ. Харин хоёр дахь үр нь хэлсэн нь: "Би маш их айж байна. Хэрвээ би үндсээ хөрсөнд ургуулбал, харанхуйд юу болж байгааг яаж мэдэх юм! Хэрвээ би газрын гадарга дээр соёогоо дэлгээд, сайхан ишээ гэмтээчихвэл яана. Мөн сайхан дэлбээгээ дэлгэхэд, өт идчихвэл яах юм бэ? Бүх зүйл аюулгүй болж сайн нөхцөл бүрдтэл зүгээр хэвтэж байсан дээр!" гэж хэллээ. Ингээд тэр удаан хүлээв. Хаврын нэгэн нартай өдөр нэг тахиа тариан талбай дээр гүйж яваад өнөөх ургаагүй үрийг олоод идчихжээ.

1. Эхний үрийн онцлог юу вэ?
 2. "Эрсдэл" гэдэг үгийн утгыг тайлбарла.
 3. Эзэнд хамаатуулах нөхцөлтэй 5 үг олж бичээрэй.
 4. "Буудайн хоёр үр тариан талбай дээр унажээ". өгүүлбэрээс цөм бүтцийг ол.
 - А. Буудайн үр Б. Үр унажээ. В. Талбай дээр унажээ.
 5. Буудайн хоёр үрийг ямар зан чанартай хүмүүс гэж үзэж болох вэ?
 6. Эхээс цагаар төгсгөх нөхцөлтэй үгсийг түүж бичээрэй.
 7. "Ургуулбал" гэх үгийг бүтцээр задлаад, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.
 8. Эхээс жинхэнэ нэр, ганц тоот, заахын тийн ялгал, эзэнд хамаатуулах нөхцөлөөр хэлбэржсэн үгийг олж бичээрэй.
 9. "Гар султай" гэх хэлцийн утгыг тайлбарлана уу.
 10. Алдаатай бичсэн үгсийг олоод, засаж бичээрэй.
- Хүйтэний оргил ханхар мөрөөрөө
Хөх тэнгрийг мөрөвчилөн зогсно.
Үүлэн хөлгөнө мөргөн батараад
Өвчүү хавид нь сэмрэн урагдна.

Эхнийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

"Эрсдэл"

Буудайн хоёр үр тариан талбай дээр унажээ. Эхний үр хэлсэн нь "Би ургахыг хүсэж байна. Би өөрийн үндсээ хөрсөнд ургуулж, соёогоо газрын гадарга дээр гарган, нарны гэрлийг харж, навчин дээрээ шүүдрийн дусал буугаасай гэж хүсэж байна." гэлээ. Удалгүй тэр хүссэнээрээ сайхан ургажээ. Харин хоёр дахь үр нь хэлсэн нь: "Би маш их айж байна. Хэрвээ би үндсээ хөрсөнд ургуулбал, харанхуйд юу болж байгааг яаж мэдэх юм! Хэрвээ би газрын гадарга дээр соёогоо дэлгээд, сайхан ишээ гэмтээчихвэл яана. Мөн сайхан дэлбээгээ дэлгэхэд, өт идчихвэл яах юм бэ? Бүх зүйл аюулгүй болж сайн нөхцөл бүрдтэл зүгээр хэвтэж байсан дээр!" гэж хэллээ. Ингээд тэр удаан хүлээв. Хаврын нэгэн нартай өдөр нэг тахиа тариан талбай дээр гүйж яваад өнөөх ургаагүй үрийг олоод идчихжээ.

1. Эхний үрийн онцлог юу вэ?
 2. "Эрсдэл" гэдэг үгийн утгыг тайлбарла.
 3. Эзэнд хамаатуулах нөхцөлтэй 5 үг олж бичээрэй.
 4. "Буудайн хоёр үр тариан талбай дээр унажээ". өгүүлбэрээс цөм бүтцийг ол.
 - А. Буудайн үр Б. Үр унажээ. В. Талбай дээр унажээ.
 5. Буудайн хоёр үрийг ямар зан чанартай хүмүүс гэж үзэж болох вэ?
 6. Эхээс цагаар төгсгөх нөхцөлтэй үгсийг түүж бичээрэй.
 7. "Ургуулбал" гэх үгийг бүтцээр задлаад, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.
 8. Эхээс жинхэнэ нэр, ганц тоот, заахын тийн ялгал, эзэнд хамаатуулах нөхцөлөөр хэлбэржсэн үгийг олж бичээрэй.
 9. "Гар султай" гэх хэлцийн утгыг тайлбарлана уу.
 10. Алдаатай бичсэн үгсийг олоод, засаж бичээрэй.
- Хүйтэний оргил ханхар мөрөөрөө
Хөх тэнгрийг мөрөвчилөн зогсно.
Үүлэн хөлгөнө мөргөн батараад
Өвчүү хавид нь сэмрэн урагдна.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Шумуул

Нэгэн шумуул зүүн гарын бугуйн дээр ирж суув. Цусанд дуртай тэр шунаг амьтныг үзэн ядах ухаан тархинд гялс хийхэд, баруун гараа далайн шумуул дээр буулгалаа. Тэр өвс шиг амьтны утас шиг амь зөвхөн салхинд нь сүйрэх бөгөөтөл ийнхүү өөрийгөө өвтгөтөл чанга цохисон нь үнэхээр шумуулд эр бяраа гаргаж хонзон санасан хэрэг болой.

1. Шумуулыг яагаад үзэн ядах сэтгэл төрсөн бэ?

- А. Цусаар хооллодог, цусанд дуртай амьтан болохоор
Б. Зүүн гарын бугуйн дээр ирж суусан болохоор
В. Өвс шиг биетэй, утас шиг амьтай болохоор
Г. Өөрийгөө өвдтөл чанга цохисон болохоор

2. Дээр эхэд юуны тухай өгүүлж байна вэ?

- А. Цусны тухай Б. Өш хонзонгийн тухай
В. Өвсний тухай Г. Өөрийгөө чанга өвтгөсөн тухай

3. Дээрх эхийн гол санааг хэлцээр зөв илэрхийлсэн хэсгийг олоорой.

- А. Муу нь муудаа, муна гадсандаа Б. Эр бяраа гайхуулах
В. Ниргэсэн хойно нь хашгирах Г. Муугаас муу модноос хөө
5. Эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.

- А. Хүүрнэмж Б. Тайлбарламж В. Тоочимж Г. Эргэцүүлэмж
6. Эхийн "Тэр өвс шиг амьтны утас шиг амь" өгүүлбэрт ямар дүрслэх ур маяг хэрэглэн бичсэн байна вэ?

- А. тойруулал Б. ихэсгэл В. адилтгал Г. зүйрлэл
7. Дагаврын аргаар бүтсэн үгийг олоорой.

- А. шумуул Б. амьтан В. хийхэд Г. цохисон

8. Эхийн "Цусанд дуртай тэр шунаг амьтныг үзэн ядав" өгүүлбэрт асуулт тавин хувиргавал онцолсон үгэнд ямар асуулт тавих вэ?

- А. Юунд? Юуг Б. Хэний? Юуг? В. Хэнд? Юуг? Г. Юуны? Юу?

9. "Нэгэн шумуул зүүн гарын бугуйн дээр ирж суув" - өгүүлбэрийн цөм бүтцийг тодорхойлоорой.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Шумуул

Нэгэн шумуул зүүн гарын бугуйн дээр ирж суув. Цусанд дуртай тэр шунаг амьтныг үзэн ядах ухаан тархинд гялс хийхэд, баруун гараа далайн шумуул дээр буулгалаа. Тэр өвс шиг амьтны утас шиг амь зөвхөн салхинд нь сүйрэх бөгөөтөл ийнхүү өөрийгөө өвтгөтөл чанга цохисон нь үнэхээр шумуулд эр бяраа гаргаж хонзон санасан хэрэг болой.

1. Шумуулыг яагаад үзэн ядах сэтгэл төрсөн бэ?

- А. Цусаар хооллодог, цусанд дуртай амьтан болохоор
Б. Зүүн гарын бугуйн дээр ирж суусан болохоор
В. Өвс шиг биетэй, утас шиг амьтай болохоор
Г. Өөрийгөө өвдтөл чанга цохисон болохоор

2. Дээр эхэд юуны тухай өгүүлж байна вэ?

- А. Цусны тухай Б. Өш хонзонгийн тухай
В. Өвсний тухай Г. Өөрийгөө чанга өвтгөсөн тухай

3. Дээрх эхийн гол санааг хэлцээр зөв илэрхийлсэн хэсгийг олоорой.

- А. Муу нь муудаа, муна гадсандаа Б. Эр бяраа гайхуулах
В. Ниргэсэн хойно нь хашгирах Г. Муугаас муу модноос хөө
5. Эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.

- А. Хүүрнэмж Б. Тайлбарламж В. Тоочимж Г. Эргэцүүлэмж
6. Эхийн "Тэр өвс шиг амьтны утас шиг амь" өгүүлбэрт ямар дүрслэх ур маяг хэрэглэн бичсэн байна вэ?

- А. тойруулал Б. ихэсгэл В. адилтгал Г. зүйрлэл
7. Дагаврын аргаар бүтсэн үгийг олоорой.

- А. шумуул Б. амьтан В. хийхэд Г. цохисон

8. Эхийн "Цусанд дуртай тэр шунаг амьтныг үзэн ядав" өгүүлбэрт асуулт тавин хувиргавал онцолсон үгэнд ямар асуулт тавих вэ?

- А. Юунд? Юуг Б. Хэний? Юуг? В. Хэнд? Юуг? Г. Юуны? Юу?

9. "Нэгэн шумуул зүүн гарын бугуйн дээр ирж суув" - өгүүлбэрийн цөм бүтцийг тодорхойлоорой.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Уртын дуу үүссэн домог

Урьд нэгэн анчин Хангай хандаа гарч явтал нэгэн буга таарч, харвах гэтэл нөгөө буга арван хоёр салаа эврээ ар зоондоо тавиад уянгалуулан урамдахад дуу нь уул нуруу дамжин цуурайтан хангинажээ. Үүнд мань эр алмайран уярч, харвахтай манатай болсон гэдэг. Ингээд уртын дууг бугын уянгаар зохиосон гэдэг домог гарчээ.

1. Эхийн үйл явдлыг дараалуулан бичээрэй.
 - Үйл явдал хаана болж байна.
 - Үйл явдалд хэн оролцсон бэ?
 - Үйл явдал хэрхэн өрнөж байна вэ? Ямар үр дүнд хүрсэн бэ?
2. Эхийн сэдвийг олоорой.
3. Үгийг бүтээврээр задалж, тайлбарлана уу.
Анчинд
4. Дараах үгийг тийн ялгалын нөхцөлөөр хувилган бичээрэй.
Толь
5. Дээрх эхээс гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олж бичээрэй.
6. Эхээс тодотгон холбох нөхцөлтэй үгсийг түүж бичээрэй.
7. Бүгдийг нь зөв бичсэн эсэхийг олоод дугуйлаарай

А. Харайя дуулая ярилцъя	В. Уншья хүлээе өгөө
Б. Зуурая хадая нэхээ	Г. Гүйе хайя хаяа оёё
8. Дараах хэлц үгийг ойролцоо утгатай хэлц үгтэй нь зөв харгалзуулаарай.

А. Хорголоо тоолох	1. Хэлээд хэлний гарз
Б. Хамхуул шиг амьтан	2. Уутны ам уруугаа харах
В. Модоо барих	3. Гар татах
Г. Тал засах	4. Өд шиг хөнгөн
Д. Чихгүй толгой	5. Хоёр нүүр гаргах
9. "Уянгалуулан" гэх үгийг бүтцээр зөв задлаарай.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Уртын дуу үүссэн домог

Урьд нэгэн анчин Хангай хандаа гарч явтал нэгэн буга таарч, харвах гэтэл нөгөө буга арван хоёр салаа эврээ ар зоондоо тавиад уянгалуулан урамдахад дуу нь уул нуруу дамжин цуурайтан хангинажээ. Үүнд мань эр алмайран уярч, харвахтай манатай болсон гэдэг. Ингээд уртын дууг бугын уянгаар зохиосон гэдэг домог гарчээ.

1. Эхийн үйл явдлыг дараалуулан бичээрэй.
 - Үйл явдал хаана болж байна.
 - Үйл явдалд хэн оролцсон бэ?
 - Үйл явдал хэрхэн өрнөж байна вэ? Ямар үр дүнд хүрсэн бэ?
2. Эхийн сэдвийг олоорой.
3. Үгийг бүтээврээр задалж, тайлбарлана уу.
Анчинд
4. Дараах үгийг тийн ялгалын нөхцөлөөр хувилган бичээрэй.
Толь
5. Дээрх эхээс гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олж бичээрэй.
6. Эхээс тодотгон холбох нөхцөлтэй үгсийг түүж бичээрэй.
7. Бүгдийг нь зөв бичсэн эсэхийг олоод дугуйлаарай

А. Харайя дуулая ярилцъя	В. Уншья хүлээе өгөө
Б. Зуурая хадая нэхээ	Г. Гүйе хайя хаяа оёё
8. Дараах хэлц үгийг ойролцоо утгатай хэлц үгтэй нь зөв харгалзуулаарай.

А. Хорголоо тоолох	1. Хэлээд хэлний гарз
Б. Хамхуул шиг амьтан	2. Уутны ам уруугаа харах
В. Модоо барих	3. Гар татах
Г. Тал засах	4. Өд шиг хөнгөн
Д. Чихгүй толгой	5. Хоёр нүүр гаргах
9. "Уянгалуулан" гэх үгийг бүтцээр зөв задлаарай.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Болжмор

Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа. Гэнэт өрөөсөн чих часхийв. Хэн юм шидчихэв ээ гэж гайхан ийш тийшээ харвал юу ч байсангүй. Чихээ гараараа дарж, нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа. "Хүүе өвөл яахаараа боргоцой байдаг билээ?" гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана. Дүү:

- Энэ болжморууд хөлдөж үхэх нь ээ гэвэл ах:

- Хоёулаа үүр хийж өгье, өнөө орой л хийе гэв.

Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа талхны үртэс тавилаа. Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой. Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад бид бас баяслаа.

1. Яагаад "Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад бид бас баяслаа." гэж хоёр хүүхэд хэлсэн бэ?
2. "олон боргоцой" гэж юуг юутай адилтгасан бэ?
3. "боргоцой, баясгалан, болжмор, үртэс, хөдөлгөөн, амьдралын" үгсийг үүсмэл ба үүсмэл бус жинхэнэ нэр гэж ялгаж бичнэ үү.
4. "Чихээ гараараа дарж нэг нүдээ аньж, нөгөө нүдээрээ дээш хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа." гэсэн хэсгээс үйл үгийг ялган таньж, тусах ба эс тусах үйл үгийн аль нь болохыг тайлбарлаарай.
5. Дараах үгсийг гээгдсэн, гээгдээгүй эгшигтэй үгээр нь ялган бичээрэй.
Үсгийн, ботгыг, албаар, шорвогийг, загасыг, аадрын, ачтаны, Орхоноос
6. Эхээс орон цагийн нэр үгсийг түүж бичээрэй.
7. "Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа" өгүүлбэрээс цөм бүтцийг ялган тэмдэглээрэй.
8. "Жиргэхийг" гэх үгийг бүтцээр задлан, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Болжмор

Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа. Гэнэт өрөөсөн чих часхийв. Хэн юм шидчихэв ээ гэж гайхан ийш тийшээ харвал юу ч байсангүй. Чихээ гараараа дарж, нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа. "Хүүе өвөл яахаараа боргоцой байдаг билээ?" гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана. Дүү:

- Энэ болжморууд хөлдөж үхэх нь ээ гэвэл ах:

- Хоёулаа үүр хийж өгье, өнөө орой л хийе гэв.

Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа талхны үртэс тавилаа. Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой. Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад бид бас баяслаа.

1. Яагаад "Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад бид бас баяслаа." гэж хоёр хүүхэд хэлсэн бэ?
2. "олон боргоцой" гэж юуг юутай адилтгасан бэ?
3. "боргоцой, баясгалан, болжмор, үртэс, хөдөлгөөн, амьдралын" үгсийг үүсмэл ба үүсмэл бус жинхэнэ нэр гэж ялгаж бичнэ үү.
4. "Чихээ гараараа дарж нэг нүдээ аньж, нөгөө нүдээрээ дээш хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа." гэсэн хэсгээс үйл үгийг ялган таньж, тусах ба эс тусах үйл үгийн аль нь болохыг тайлбарлаарай.
5. Дараах үгсийг гээгдсэн, гээгдээгүй эгшигтэй үгээр нь ялган бичээрэй.
Үсгийн, ботгыг, албаар, шорвогийг, загасыг, аадрын, ачтаны, Орхоноос
6. Эхээс орон цагийн нэр үгсийг түүж бичээрэй.
7. "Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа" өгүүлбэрээс цөм бүтцийг ялган тэмдэглээрэй.
8. "Жиргэхийг" гэх үгийг бүтцээр задлан, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.